



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/63/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт	20
Байхгүй	20
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ДЭЛҮҮН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ П.АХТОРГАЙ ТАНАА

᠒᠐᠒᠒.᠐᠗.᠒᠒ № 13᠒
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>39,158,781.99</u>	<u>33,058,948.40</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
31140	Касс арилжааны банк	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31213	Арилжааны банк дахь харилцах	-	-
33	АВЛАГА	<u>1,460,292.59</u>	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,141,292.59	
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
335	Бусад авлага	319,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	319,000.00	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>37,698,489.40</u>	<u>33,058,948.40</u>
354	Хангамжийн материал	37,698,489.40	33,058,948.40
35410	Бичиг хэргийн материал	335,000.00	331,500.00
35420	Аж ахуйн материал	7,083,300.00	8,775,322.00
35440	Түлш, шатах тослох материал	2,769,912.92	2,574,012.92
35460	Хүнсний материал	12,215,636.48	6,083,473.48
35470	Бусад хангамжийн материал	15,294,640.00	15,294,640.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>157,793,141.14</u>	<u>84,854,431.91</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	157,793,141.14	84,854,431.91
392	Биет хөрөнгө	155,793,141.14	82,854,431.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	150,824,761.81	71,593,803.81
39202	Хуримтлагдсан элэгдэл	(11,949,050.45)	(11,311,978.85)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	19,449,038.00	22,747,038.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(15,948,686.80)	(16,998,647.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,522,675.00	23,822,675.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,351,281.42)	(14,230,323.89)
39214	Бусад үндсэн хөрөнгө	797,500.00	797,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(797,500.00)	(797,500.00)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	-
39217	Ном	3,245,685.00	7,231,865.00
393	Биет бус хөрөнгө	<u>2,000,000.00</u>	<u>2,000,000.00</u>
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,000,000.00	2,000,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>196,951,923.13</u>	<u>117,913,380.31</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>236,850.16</u>	<u>-</u>
413	Өглөг	236,850.16	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	236,850.16	
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>196,715,072.97</u>	<u>117,913,380.31</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	196,715,072.97	117,913,380.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	37,314,149.00	37,314,149.00
51101	Өмч: - төрийн	37,314,149.00	37,314,149.00
512	Хуримтлагдсан үр дүн	98,798,899.67	19,997,207.01
51210	Өмнөх үеийн үр дүн	100,400,945.26	98,798,899.67
51220	Тайлант үеийн үр дүн	(1,602,045.59)	(78,801,692.66)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	60,602,024.30	60,602,024.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>196,951,923.13</u>	<u>117,913,380.31</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	235,173,156.00	264,990,480.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,440.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	33,440.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	33,440.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	235,139,716.00	264,990,480.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	222,227,716.00	229,780,480.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	4,826,616.00	3,856,180.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	217,401,100.00	225,924,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,480,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,480,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	12,912,000.00	30,730,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,912,000.00	10,730,000.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	-	20,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	236,741,761.59	249,522,762.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	236,741,761.59	249,522,762.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	221,072,711.59	244,234,148.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,339,749.57	182,178,922.77
210101	Үндсэн цалин	156,165,549.57	168,836,295.77
210104	Урамшуулал	14,174,200.00	8,555,404.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	4,787,223.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,351,000.00	24,659,223.66
210201	Тэтгэврийн даатгал	15,024,800.00	20,364,023.66
210202	Тэтгэмжийн даатгал	1,581,600.00	1,073,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,265,200.00	859,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	316,300.00	214,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,163,100.00	2,147,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,327,880.00	11,349,422.00
210301	Гэрэл, цахилгаан	1,279,080.00	759,602.00
210302	Түлш, халаалт	8,258,800.00	9,089,820.00
210303	Цэвэр, бохир ус	1,790,000.00	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,549,490.00	5,733,258.00
210401	Бичиг хэрэг	132,500.00	361,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,701,000.00	1,163,080.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	545,300.00	682,300.00
210404	Ном, хэвлэл	11,500.00	87,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	159,190.00	3,438,978.00
2105	Нормативт зардал	5,958,444.06	9,736,743.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	57,900.00	79,500.00
210502	Хоол, хүнс	5,900,544.06	9,401,643.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	255,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	-	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	279,100.00	86,000.00
210702	Дотоод албан томилолт	279,100.00	86,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	312,500.00	412,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	312,500.00	312,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,954,547.96	9,578,079.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,280,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	373,400.00	1,044,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,581,147.96	7,253,479.07
210904	Найдваргүй авлагын алдагдал	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,669,050.00	5,288,614.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,880,300.00	4,746,120.00

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,880,300.00	4,746,120.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	282,398.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	282,398.00
213404	Хөрөнгийн	-	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,788,750.00	260,096.00
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,788,750.00	260,096.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж	-	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,568,605.59)	15,467,717.50
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	94,269,410.16
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	94,269,410.16
225002	Найдваргүй авлагын алдагдал	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(94,269,410.16)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,568,605.59)	(78,801,692.66)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан мөнгө	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	37,314,149.00	60,602,024.30	98,798,899.67	196,715,072.97
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,314,149.00	60,602,024.30	98,798,899.67	196,715,072.97
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,314,149.00	60,602,024.30	98,798,899.67	196,715,072.97
D01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	37,314,149.00	60,602,024.30	98,798,899.67	196,715,072.97
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,314,149.00	60,602,024.30	98,798,899.67	196,715,072.97
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D08	Тайлант үеийн үр дүн			(78,801,692.66)	(78,801,692.66)
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,314,149.00	60,602,024.30	19,997,207.01	117,913,380.31

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>230,313,100.00</u>	<u>241,134,300.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	230,313,100.00	241,134,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	217,401,100.00	225,924,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
131005	Хөрөнгийн санхүүжилт		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	217,401,100.00	225,924,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,480,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,480,000.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	12,912,000.00	10,730,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,912,000.00	10,730,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>230,093,100.00</u>	<u>236,406,300.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	230,093,100.00	236,406,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	214,423,950.00	231,119,306.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,483,800.00	181,562,904.00
210101	Үндсэн цалин	145,309,600.00	159,394,100.00
210104	Урамшуулал	14,174,200.00	8,555,404.00
210105	Гэрээт ажлын хөлс		13,613,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,351,000.00	24,370,800.00
210201	Тэтгэврийн даатгал	15,024,800.00	17,149,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,581,600.00	1,805,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,265,200.00	1,444,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	316,300.00	361,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,163,100.00	3,610,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,912,000.00	9,947,602.00
210301	Гэрэл, цахилгаан	1,207,000.00	440,602.00
210302	Түлш, халаалт	9,915,000.00	8,007,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,790,000.00	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,032,250.00	6,639,500.00
210401	Бичиг хэрэг	203,500.00	384,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,701,000.00	2,050,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	595,300.00	682,300.00
210404	Ном, хэвлэл	60,500.00	87,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	471,950.00	3,435,300.00
2105	Нормативт зардал	10,366,900.00	3,861,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	57,900.00	79,500.00
210502	Хоол, хүнс	9,567,400.00	3,270,600.00

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	741,600.00	511,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	500,000.00
210604	Урсгал засвар		500,000.00
2107	Томилолт, зочны зардал	279,100.00	86,000.00
210702	Дотоод албан томилолт	279,100.00	86,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	312,500.00	412,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	312,500.00	312,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,686,400.00	3,738,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,280,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,686,400.00	2,458,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,669,150.00	5,286,994.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,880,400.00	4,744,500.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,880,400.00	4,744,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	282,398.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		282,398.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,788,750.00	260,096.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,788,750.00	260,096.00
213504	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>220,000.00</u>	<u>4,728,000.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
140002	Улсын төсвөөс олгосон зээл		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	220,000.00	4,728,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	220,000.00	4,728,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	220,000.00	4,728,000.00
220001	Барилга байгууламж		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	220,000.00	4,728,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(220,000.00)</u>	<u>(4,728,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	236,654,300.00	236,111,806.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	236,654,300.00	236,111,806.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	231,909,800.00	231,367,306.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,565,600.00	181,562,904.00
210101	Үндсэн цалин	159,394,100.00	159,394,100.00
210104	Урамшуулал	8,558,100.00	8,555,404.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,613,400.00	13,613,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,370,800.00	24,370,800.00
210201	Тэтгэврийн даатгал	17,149,900.00	17,149,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,805,200.00	1,805,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,444,200.00	1,444,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	361,000.00	361,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,610,500.00	3,610,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,230,000.00	9,947,602.00
210301	Гэрэл, цахилгаан	888,000.00	440,602.00
210302	Түлш, халаалт	7,842,000.00	8,007,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,354,500.00	7,354,500.00
210401	Бичиг хэрэг	79,000.00	79,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,890,000.00	1,890,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	682,300.00	682,300.00
210404	Ном, хэвлэл	112,900.00	112,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,590,300.00	4,590,300.00
2105	Нормативт зардал	4,014,100.00	3,861,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	79,500.00	79,500.00
210502	Хоол, хүнс	3,423,300.00	3,270,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	511,300.00	511,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	90,300.00	86,000.00
210702	Дотоод албан томилолт	90,300.00	86,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	512,900.00	412,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	112,900.00	100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	312,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,271,600.00	3,271,600.00

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,271,600.00	3,271,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,744,500.00	4,744,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,744,500.00	4,744,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,744,500.00	4,744,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	236,654,300.00	236,111,806.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	225,924,300.00	225,381,806.00
131001	Улсын төсвөөс санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	225,924,300.00	225,381,806.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,730,000.00	10,730,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	10,730,000.00	10,730,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18	21
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	6	8
620003	Үйлчлэх ажилтан	8	10
620004	Гэрээт ажилтан	3	2
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	52	52
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	52	52
630001	Төрийн өмчит ЕБС	52	52
630002	Хувийн ЕБС		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	18	21
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	7	8
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	10
650010	Гэрээт ажилтан	3	3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	4,480,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	4,480,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	4,480,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,760,000.00
210401	Бичиг хэрэг		305,000.00
210402	Тээвэр, шатахуун		160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,295,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,720,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,280,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,440,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	4,480,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,480,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,480,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн №Б/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь: Ерөнхий боловсролын бага боловсрол олгох, хүүхдүүдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмшүүлэх, боловсролын зорилгыг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Тайлант онд сургууль нь: Сургалтын чанарыг сайжруулах, багш, ажилтны цаг ашиглалтыг чанд сахих, хичээлийн бэлтгэл сайжруулах, аргагүй, ур чадвар, мэдлэг боловсролыг тасралтгүй дэвшүүлэх, сурагчдын сурч боловсрох боломжийг нэмэгдүүлэх, хүүхдийн хүмүүжил, хөгжил хамгааллын асуудлаар эцэх, эх асран хамгаалагчидтай хамтран ажиллах зорилго тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус сургуульд дотоод аудитор ажилладаггүй, тайлант онд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж, шалгалтаар 2.0 сая төгрөгийн илүү цагийн зөрүүг буцаан олгох төлбөрийн акт тогтоосныг барагдуулж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 236.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79.0 сая төгрөгөөр буюу 40.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлагын, бараа материалын, үндсэн хөрөнгийн дансууд буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	1,460.30		(1,460.30)
Урьдчилгаа			-
Бараа материал	37,698.50	33,058.90	(4,639.60)
Үндсэн хөрөнгө	157,793.10	84,854.40	(72,938.70)
Нийт хөрөнгө	196,951.90	117,913.30	(79,038.60)
Өр төлбөр	236.90		(236.90)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	196,715.00	117,913.30	(78,801.70)

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	196,951.90	117,913.30	(79,038.60)
---	-------------------	-------------------	--------------------

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй, оны эхний 1.5 сая төгрөгийн авлагыг барагдуулж, оны эцэст авлагагүй, урьдчилж гарсан зардал дансанд үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 33.0 төгрөг болж 4.6 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оноос аж ахуйн материал, бичиг хэрэг, хүнсний материалын үлдэгдлүүд буурсантай холбоотой байна. Тайлант онд 24.4 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 29.0 сая төгрөгийн материал зарцуулжээ.

Хүнсний материалын дансанд оны эхэнд 12.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 8.6 сая төгрөгийн хүнс худалдан авч, 14.1 сая төгрөгийн материалыг зарцуулж жилийн эцэст 6.1 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй гарсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 84.9 сая төгрөг болж 72.9 сая төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, үндсэн хөрөнгийн элэгдэл, акталсан хөрөнгийн зөрүүгээр буурсан үзүүлэлттэй харагдаж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 4.7 сая төгрөгийн, БШУЯ-наас үнэ төлбөргүй 3.9 сая төгрөгийн ном, сумын ОНХС-аас 20.0 сая төгрөгийн барилгын засвар, нийт 29.9 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 126 тоот тогтоолоор 99.2 сая төгрөгийн барилгыг акталсан байна. Уг барилга нь 2019 онд 53 хүүхдийн багтаамжтай ашиглалтад орсон боловч газрын мөнх цэвдгийн улмаас мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр актлагдсан байна.

Өр төлбөр дансны оны эхний 0.2 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, оны эцэст өглөггүй, Засгийн газрын оролцоо дансанд өөрчлөлт гараагүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 265.0 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 24.6 сая төгрөгөөр буюу 10.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсвийн урсгал болон нэмэлт санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн санхүүжилтүүд байна.

Нийт зардал өмнөх оноос 7.6 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, НДШ, нормативт зардал, хангамж бараа материалын, эд хогшлын, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны ээлжит II хуралдааны 16 дугаар тогтоолоор тус сургуулийн төсвийг тусгай зориулалтын шилжүүлгээс 229.5 сая, орон нутгийн төсвөөс 10.7 сая төгрөг, нийтдээ 240.2 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны Төсвийн сарын зохицуулсан хуваарь батлах тухай А/1093 тоот захирамжаар тус сургуулийн батлагдсан төсвийг 236.6 сая төгрөг болгон өөрчилсөн байна.

Энэ нь анх батлагдсан төсвөөс хоолны зардлаас 23.0 сая, үдийн цайны зардлаас 3.0 сая төгрөгөөр бууруулж, цалин, үр дүнгийн урамшууллын зардлыг 14.1 сая, НДШ-ийн зардлыг 1.8 сая, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс 4.2 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 2.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, батлагдсан төсвийг нийт дүнгээр 3.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалин, урамшууллын зардлыг 14.1 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийг 1.8 сая төгрөгөөр дутуу суулгасантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 236.7 сая төгрөгийн төсөв баталснаас 225.9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 10.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр төсвөөс 225.4 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 10.7 сая төгрөг, нийт 236.1 сая төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 236.1 сая төгрөгийг зарцуулж, 0.5 сая төгрөгийг хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна. Хэмнэсэн зардлуудад тогтмол зардлыг 0.3 сая, нормативт зардлыг 0.1 сая, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн зардлуудыг 0.1 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр арга хэмжээ, батлагдсан төсөв гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Арга хэмжээ	Нэршил	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	70802	70602	Ерөнхий боловсрол			
2		80109	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	10730.0	10447.6	282.4
3		81801	үдийн цай хөтөлбөр	4744.5	4744.5	-
4		81806	Дотуур байрны үйлчилгээ	43391.8	43239.1	152.7
5		81834	Боловсролын стандарт, сургалтын	91597.4	91580.2	17.2
6		81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	86190.6	86100.4	90.2
Нийт дүн				236654.3	236111.8	542.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Боловсролын газраас ариутгалын зардалд 0.2 сая, тэтгэлэгт хөтөлбөрийн зардалд 4.3 сая, нийтдээ 4.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэн зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийг 1 хөтөлбөр, 1 төсөл арга хэмжээний зардалд 1.9 сая төгрөгийг хангамж бараа материалын, 2.7 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардлуудад тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардалд 181.6 сая, НДШ-ийн зардалд 24.4 сая, халаалтын зардалд 8.0 сая, урсгал засвар, эм, хоол, үдийн цайны зардалд 8.1 сая төгрөг, нийтдээ 222.0 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэл нийт 236.1 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлын дүн 222.0 сая төгрөгийг хасахад 14.1 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 1.4 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба 2021 онд төсвөөс 0.5 сая төгрөгийн хэмнэж, 0.9 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй тул Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдаагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 2021 онд нийт 238.1 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 138.1 сая 109 мэдээллийг хугацаанд ил тод байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний материалыг бодит хэрэгцээнд үндэслэн худалдан авалт хийх, гарч болох эрсдэлийг урьдчилан тооцож, чанар байдлаа алдаж муудахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4 дэх заалтыг баримталж хэмнэлттэй зардлыг хүрэлцээгүй зардалд зайлшгүй шаардлагын үүднээс шилжүүлэн зарцуулахдаа холбогдох байгууллагуудаас зохих зөвшөөрлийг авч ажиллах талаар 2 заалттай зөвлөмж өгөгдсөн ба өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц онц асуудал байхгүй, санхүүгийн тайлангийн аудитыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул төсвийн зарцуулалтыг бүрэн үзэх шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 0.9 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрч, зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1.Тус сургууль нь тайлант онд Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь 0.9 сая төгрөгийг хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	1	0.9					1	0.9		